



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ШИНЭЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 96

Залаа

「Сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний」  
биелэлтийг хэлэлцэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.5 заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1.Сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 89% "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсүгэй.

2.Хөгжлийн төлөвлөгөөний үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн дүгнэх товчоог 1 дүгээр хавсралтаар баталсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Цэнгэлмаа)-д даалгасугай.

ДАРГА  Н.ЖАРГАЛСАЙХАН



642301024

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хуралдааны  
2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 96 дугаар  
тогтоолын 2.1 дүгээр хавсралт



**ШИНЭЖИНСТ СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
2023 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2023 оны 12 дугаар сарын 19

Залаа

СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО		
<b>Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо:37</b>		
Үүнээс:	<b>Үр дүнтэй: 100%</b>	28
	<b>Тодорхой үр дүнд хүрсэн: 90-70%</b>	90%-3, 70%-2
	<b>Эрчимжүүлэх шаардлагатай: 50-30%</b>	50%-1, 30%-1
	<b>Үр дүнгүй: 0</b>	2
Хөгжлийн төлөвлөгөөний 2023 оны биелэлт <b>89 хувь</b> байна.		

.....оОо.....

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН  
2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 15

Залаа

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн		2023 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч	Биелэлт
				Суурь түвшин /2022 он/	Зорилтот түвшин /2023 он/	Санхүүжилтийн хэмжээ /сая.төгрөг/	Санхүүжлтийн эх үүсвэр		
1	2	3	4	5	6	7	8	9	10
<b>НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>									
1	1.1.Эрүүл иргэн - Ирээдүйн үнэт зүйл	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар	Гүйцэтгэлийн хувь	0	90	50.0	Орон нутгийн хөгжлийн сан	Эрүүл мэндийн төв	Сумын Эрүүл мэндийн төвийн 2 давхар эмнэлгийн их засварын ажлаас 2023 онд батлагдсан төсвөөс үүдний металл хаалга, Даргын өрөө, лаборант, Бичиг хэрэг, мөн гадна 2 хаалгуудыг металл төмөр хаалгаар шинэчлэн “Плутус-Велт” ХХК гүйцэтгэн ажилласан. Гадна болон дотор их засварын ажлыг 2024 оны эхний хагас жилд хийж дуусгахаар төлөвлөж байна. <b>Тодорхой үр дүнд хүрсэн 90%</b>
2		Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан эрт илрүүлэг үзлэгийг чанаржуулах	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь	0	30		Эрүүл мэндийн даатгалын сан	Эрүүл мэндийн төв	Шинэжинст сумын нийт 2586 хүн амаас 18-аас дээш насны 1653, 0-17 насны 933 иргэн байна. 2023 онд Эрт илрүүлэгт хамрагдах 18-аас дээш насны хүн амын тоо 960 байгаагаас хамрагдсан хүний тоо 210 хүн Баянхонгор аймагт, 2023 оны 09 сарын 10-нд Улсын 2-р төв эмнэлэгт эрт илрүүлгийн үзлэг хийх хуваарийн дагуу 30 иргэн эрт илрүүлэгт хамрагдсан буюу 21.8%-тай байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>0-17 насны 192 хүүхэд хамрагдсан буюу 20,5%- тай байна.</p> <p>Шинэжинст сумын нийт иргэдийн эрт илрүүлэгт илэрсэн өвчлөлийн байдал нь N11-79%, K86-56%, K29-45%, B18-21%, I10-56% өвлөл илүү байна.</p> <p><b>Эрчимжүүлэх шаардлагатай 30 хувь</b></p>
3		Хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	100			Эрүүл мэндийн төв	<p>Сургуулийн өмнөх боловсролын 150 хүүхэд, Ерөнхий боловсролын сургуулийн 340 хүүхэд амны хөндийн үзлэгийг зохион байгуулсан. Үүнээс 10 хүүхэд тутмын 8 нь шүдний өвчлөлтэй байсан. 2023 оны 08 сарын 25-нд 50 хүүхдийг шүдний эмчийн үзлэгт хамруулж эрүүлжүүлсэн. Бусад илэрсэн амны хөндийн өвчлөлтэй хүүхдүүдэд зөвлөгөө өгч 2-р шатлалын эмнэлэгт илгээсэн.</p> <p><b>Үр дүнтэй 100 хувь</b></p>
4		Өсвөр насны охид, хөвгүүдийн нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлж охидын төрөлтгүй болох	Сургалтын давтамж, хамрагдалтын тоо, охидын төрөлтийн тоо	0	100			Эрүүл мэндийн төв	<p>Ерөнхий боловсролын сургуулийн өсвөр насны охид хөвгүүдийн дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг ахлах ангийн 210 сурагчдад хийж, гарын авлага тарааж бүртгэл хөтөлсөн. Сургалтын өмнөх сорил 62% байсан бол сургалтын дараа 84% болж өссөн. Мөн дотуур байрны охидод “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” “Цэвэр гар-эрүүл мэнд” “Зөв зохистой хооллолт” “Электрон тамхины хор уршиг”</p>

1											
2											
3											
4											
5											
6											
7											
8											
9											
10	<p>зэрэг сэдвүүдээр 2 удаагийн сургалтыг 31 охиод, нийт 118 өсвөр насныханд сургалт хийж, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Сургалтын өмнөх сорилыг авахад 65% байсан бол сургалтын дараах сорилд 80% болж нэмэгдсэн үр дүнтэй байна.</p> <p>Үлсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Спорт заал" шинээр барих ажлыг "Баян арвижих од" ХХК 873 сая төгрөгөөр бүрэн дуусаж хийж гүйцэтгэсэн. 2022 оноос ажил эхэлж нийт гүйцэтгэх ажлын 80%-ийг хийж, 2023 онд үлдэх 20%-ийн ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан аймагас мэргэжлийн байгууллагаас хариуцсан мэргэжилтнүүдийг авчирч газар дээр нь шалгуулан дутуу байсан ажлуудыг гүйцээн хүлээн авсан.</p>	<p>Үр дүнтэй 100 хувь</p>	<p>Засаг даргын газар</p>	<p>Биеийн тамирын гадаа талбай байгуулах</p> <p>Спорт заалыг</p>	<p>Барилгын гүйцэтгэл ин чанар</p>	0	100	873.0	<p>Орон нутгийн хөгжлийн сан</p>	<p>Засаг даргын газар</p>	<p>Үр дүнтэй 100 хувь</p> <p>Биеийн тамирын гадаа талбай байгуулах 1,412,471,400 төгрөгийн төсөвт өртөтэй ажлыг төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтаар цахим хэлбэрээр зарлаж "Элбэг констракшн" ХХК-тай 1,367,898,542 төгрөгийн гэрээ байгуулж 886,879,200 төгрөгийн ажлыг 2023 онд хийхээр гэрээнд тусгагдаж ажлын гүйцэтгэлд ИТХ, ЗДТГ-аас байгуулагдсан ажлын хэсэг зохион хяналт тавьсан.</p> <p>Эрчимжүүлэх шаардлагатай 50 хувь</p>
6											

10	Шинэжинст сумын нийт ард иргэдийн дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлэх зорилгоор уралдаан тэмцээнүүдийг цаг тухайд нь зохион байгуулж ажигласан. "Цаг гаргая аян"-г сум орон нутагтаа зохион байгуулж ахмад настан, албан байгууллага, ард иргэд, хүүхэд залуус оролцсон. Энэхүү аянд 3 сарын турш давхардсан тоогоор 675 хүн өглөөний дасгал, нарны алхалтанд хамрагдсан байна. "Эрдэнэт сүргийн эзэд – 1000" чуулган урлаг спортын наадамд оролцож спортын 7 төрлөөр өрсөлдөж Шинэжинст сум нийт оноогоор 7-р байрт шалгарсан. Баянхонгор аймгийн говийн бүсийн сумдын ИТХ, Засаг даргын тамгын газрын албан хаагчдын нөхөрсөг уулзалт баацагана сумд болж спорт урлагийн арга хэмжээ болсон. Шинэжинст сум тэргүүн байр эзэлж 3,000,000₮-өөр шагналуулсан. "2023 оны аварга" шагналуулах тэмцээнийг 11 сарын 15-ны өдрөөс 17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Давхардсан тоогоор 75 төрийн албан хаагч болон, ард иргэд оролцсон.	Үр дүнтэй 100 хувь
9	Биеийн тамирын арга зүйч	
8		
7		
6	100	
5	0	
4	Хамрагдсан иргэдийн тоо, амжилт	
3	Бүх нийтийн спортын арга хэмжээ зохион байгуулах	
2		
1	7	

1	8	Боловсролын Хөгжлийн чанар - лын 1.3 тулгуур	Боловсролын орчин бүрдүүлэх ЭКО	Стандарт	0	100	85.0	Хандив тусламж, Орон нутгийн хөгжлийн сан	Боловсрол ын Ерөнхий сургууль	<p>Бсүргүүл нь гаднаа 0.7га газарт ногоон байгууламжтай бөгөөд тус талбайд хайлаас, улиас, чяцаргана, сүхай гэсэн 4 төрлийн моднуудыг тарьж байна. Намар чяцарганы талбайгаас 10кг ургац хураасан. Мөн Монгол Улсын Засгийн газар, Хорбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд байгуулсан бүцэлтэй тусламжийн хүрээнд Германы Сэргэн босголын Зэргийн Банкаар дамжуулан БОАЖЯ-ны хэрэгжүүлж буй "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төслийн хүрээнд тус сургууль нийт 65ая төрөний сургалтга хүүн бүхий эко танхимыг байгуулах ажил хийгдэж байна. Одоогоор 6,146.00 төрөний хэрэглэгдэхүүн хүлээж авсан. Тус төслийн хүрээнд 3 багш нэг удирдах ажилтан Говь-Алтай аймагт эко танхим байгуулах сургалтад хамрагдаж ирлээ. Эко мазахай эко клубын үйл ажиллагаа тогтмол явагдаж байна бөгөөд Говь-Алтай аймгийн Лотт суманд "Нүүдэлчин авдар" сургалтын хэрэглэгдэхүүнийг түршгара солигдох сургалтад 5, Орчны бүсийн эко клубуудын чуулга уулзалтад 9 сургалт тус тус оролцож 2023-2024 оны төлөвлөгөө хийж хэрэгжүүлэх 10</p>
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										

1	2	3	4	5	6	7	8	9	10
									ажлыг хэлэлцсэн. Цэцэрлэг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар урлагын заалны иж бүрэн засвар хийж хүүхдийн онцлогт тохируулан тайзны арын ханыг акустик хавтангаар хийлгэж тайлан тоглолт явуулах тайз, сургалт үйлчилгээ явуулах ухаалаг дэлгэц болон хүүхэд бүрийн насанд тохирсон хөгжмийн зэмсэгүүдээр бүрэн хангагдаад байгаа ба хүүхдэд ээлтэй эко орчин бүрдээд байна. <b>Тодорхой үр дүнд хүрсэн 90%</b>
9		Бүх боловсролын байгууллагын сургалтын үзүүлэлт, хүртээмжийг сайжруулах чанарын тэгш	СӨБ, ЕБС-Д хамрагдалтын тоо Боловсролын үйлчилгээн ий чанарын ахиц	0	100			Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг	Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу чанартай тэгш хүртээмжтэй хүргэхэд үйл ажиллагаагаа төлөвлөж хэрэгжүүлж байгаа бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр 15 суралцагчидтай хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байна. 15 суралцагчийн эцэг эх, сургуулийн захиргаатай гуравласан гэрээ байгуулж ажиллаж байна. Тойргийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах 2-5 настай нийт 262 хүүхдээс 60 хүүхэд нь өөр аймаг суманд хамрагдсан байгаа ба хамран сургах 202 хүүхдээс үндсэн бүлэгт 125 хүүхэд, явуулын бүлэгт 30 хүүхэд хамруулж нийт хамрагдалт 77%-тай байна. Бэлтгэл бүлэгт хамрагдан сургуульд элсэх 5



1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>настай нийт 43 хүүхдээс -үндсэн бүлэгт 35 -явуулын бүлэгт 8 хүүхдийг хамруулан нийт 5 настай хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд 100% бүрэн хамруулаад байна. <b>Үр дүнтэй 100 хувь</b></p>
10		<p>Насан туршийн боловсролын чанарыг хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх цахим сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлэх</p>	<p>Сургалтад хамрагдсан хүний тоо, амьдралын чанарын өсөлтийн хувь</p>	0	100			<p>Насан туршын боловсрол ын багш</p>	<p>Цахим ур чадварын 30 цагийн төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Цахим дээр анхан шатны сургалтад 5 иргэнд 2 цаг, E-mongolia сургалтад 4 цаг, Gmail дээр хаяг нээх яаж ашиглах талаар сургалтад 4 цаг, 5 иргэнд нийт 10 цагийн хичээл орсон. Бичиг үсгийн сургалтыг нэг Багийн Засаг Дарга нартай хамтарч 4 багийн 7 иргэдийн ар гэрээр айлчлал хийж даалгавар өгч ажиллалаа. Үүний үр дүнд 3 иргэн танхимын сургалтыг 2 удаа авсан. Анхан шатанд 2, Дунд шатанд 3, Гүнзгий шатанд 2 иргэн хамрагдаж байна. “Алхам алхмаар” аяны мэдээллийг тухай бүрд нь Шинэжинст сумын насан туршийн боловсролын группэд байршуулж байна. 8а ангид нэг удаа хичээл орж Алхам алхмаар цахим хуудсанд нэгдүүлж 20 сурагчаар тест сорил туршилт хийж ямар мэргэжилтэй болбол зохиох талаар сорил авлаа. “Миний эрхэмлэх үнэт зүйл, миний мэргэжил постер уралдаан”-д 9-р ангийн 5 сурагчийн постер, 8-р ангийн Эсээ бичлэг, 2 сурагчийн бүтээлүүдийг холбогдох</p>

1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>байгууллагад хүргүүлсэн. Дэлхийн усны өдөр, мазаалайн өдрүүдийг тохиолдуулан 6-9 ангийн сурагчдын дунд ханын сонин хийх уралдааныг 2 удаа зохион байгуулсан. Дунд ангийн 7 бүлэг оролцсон. Төрийн албан хаагчдад ҮЭ дарга Ц.Хуяг хөдөлмөрийн тухай хуулиар захиалгат сургалтыг 2023 оны 02 сарын 16 нд соёлын төвд нийт 54 хүнд хийв. Сумын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарч “Нандин холбоо” арга хэмжээн дээр “Эмэгтэйчүүд гэж хэн бэ” “Эмэгтэйчүүд гайхамшигт ертөнц” гэсэн лекцүүдийг уншлаа. Нийт 68 иргэн хамрагдсан. Сурагчдад “Мөнгө, мөнгөний үнэ цэнэ”, “Санхүүгийн боловсрол” сэдвээр сургалт орсон. Дараа нь хөгжилтэй тоглоом явуулж 1-3 байр эзлүүлж ХААН БАНК ивээн тэтгэж явуулсан. Дэлхийн мөнгөний долоо хоног Цахим сургалтад 20 сурагчдыг хамрууллаа. Мөн ХААН БАНК-тай хамтарч 7-9 ангийн нийт 58 Сургуулийн асран хамгаалагчийн дунд өртөөлчилсөн сургалтыг Удирдамжийн дагуу явуулсан. 4 өртөө дээр сургалт мэдээлэл хийсэн дараа нь ирсэн хүмүүсийг багт хувааж гар бөмбөг, буухиа, АХА тэмцээнүүд явууллаа. Энэ үйл ажиллагаанд нийт 105 эцэг эх оролцлоо.</p> <p>2023 оны 10 дугаар сарын</p>

1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>26-27 өдрүүдэд 8-р ангийн 31 сурагчдад, 11 сард 9 –р ангийн 40 сурагчдад “Өөрийгөө таньж мэдэх” “Миний зан төлөв темперамент” “Сонирхлоо зөв тодорхойлох” “Үнэт зүйл ” гэсэн 4 багц сургалтыг зохион байгуулж явуулсан. Энэ жил Насан туршийн боловсролын 5 чиглэлээр нийт 40 төрлийн сургалтыг 1116 иргэнд явуулсан байна.</p> <p><b>Үр дүнтэй 100 хувь</b></p>
11	1.5. Халамжаас-Хөдөлмөрт	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх	Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	0	100			Нийгмийн бодлогын мэргэжилтэн	<p>Хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөр арга хэмжээнд хамрагдах тухай заавар, зөвлөмжийг цахимаар мэдээлж ажиллаж, санхүүгийн дэмжлэг хүссэн 1 иргэний төсөлд 6 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг хүссэн 1 иргэний төсөлд 4 сая, нийт 10 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатай, хүүгүй олгож дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2023 онд 5 залуу малчин өрхийг хамруулан тус бүр 5 сая, нийт 25 сая төгрөгөөр малжуулсан. Эргэн төлөлтийг 36 сарын хугацаанд хүүгүй төлж, барагдуулах нөхцөлтэй. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчлэгээний төсөлд 1 ахмад настны төслийг хүлээн авч Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт хүргүүлэн</p>

1	2	3	4	5	6	7	8	9	10
									ажилласан. “Амралтаараа ажиллая” оюутан хөтөлбөрийг “Эрдэнэмонгол” ХХК-тай хамтран хэрэгжүүлж зуны амралтын хугацаанд 19 оюутанг ногоон байгууламж, бусад ажилд дагалдангаар ажиллуулж ажлын байраар хангаж ажиллалаа. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
12		Зорилтод бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах	Ажлын байранд зуучилсан иргэдийн тоо	0	100			Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Суманд үйл ажиллагаа явуулдаг бүх төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгчид 2023 онд нийт 35 иргэн сул чөлөөтэй ажлын байраар хангагдан ажилласан мэдээ судалгаа гарсан. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
13		Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангах	Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо	0	100			Нийгмийн даатгалын байцаагч	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний сайн дурын даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэх тухай хуулийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, мөн ажил олгогчдын тоог нэмэгдүүлэх, тэдний гар утсанд “Нийгмийн даатгал” аппликейшнийг суулган өгч ашиглах зааврыг тайлбарлах, хэрэглээг нь нэмэгдүүлж, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ болон ач холбогдлыг таниулаж 4 удаа дөрвөн багруу явж сургалт хийж нийт давхардсан тогоор 845 иргэн хамрагдлаа. жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 257

1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>даатгуулагч хамруулсны 225 нь “Малчин” байгаа нь сайн дурын даатгалд хамрагдаж байгаа иргэдийн 90%-ийг эзэлж байна. 2023 оны жилийн байдлаар нийт Сайн дурын 257 даатгуулагчидтай гэрээ хийсэн. Үүнээс шинээр нийт 46 иргэнтэй сайн дурын гэрээ байгууллаа, Гэрээнд заасны дагуу төлөх шимтгэлийг тооцон авч 257 даатгуулагч хамруулж 2023 оны 11 дүгээр сарын 29-ны байдлаар 195,945,730 төгрөгийн орлого оруулахаас 178,765,841 төгрөг хуримтлагдсанаар 91 хувиар биелүүлээд байна.</p> <p>Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлд нийт 24 эхийг хамруулж жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд 10 784 510 төгрөгийн орлого оруулахаас 9,771,030 төгрөгийг хуримтлагдсанаар 90 хувиар биелүүлээд байна.</p> <p>Эхийн хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлд нийт 20 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 9,115,880 төгрөгийн орлого оруулахаас 8,293,100 төгрөгийг хуримтлагдсанаар 90 хувиар биелүүлээд байна.</p> <p>Эрүүл мэндийн даатгалд иргэдийг хамруулж 20,719,660 сая төгрөгийн орлого оруулахаас</p>

1	2	3	4	5	6	7	8	9	10
									256 даатгуулагчдыг хамруулж 23,856,600 төгрөгийн орлого хуримтлагдсанаар 115 хувиар биелүүлээд байна. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
14		Нийт тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах	Цахимжсан хувийн хэргийн тоо	0	100			Нийгмийн даатгалын байцаагч	2023 онд шинээр Өндөр настан болон малчин тэтгэвэр тогтоолгож буй 5, хүүхдээр тэтгэвэр тогтоолгож буй 6, энгийн тэтгэвэр тогтоолгож буй 3, жилийн нэмэгдэл 2, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, тахир дутуугийн тэтгэвэр 5 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийн бүрдэл холбогдох баримт материалыг үндэслэн тогтоолт олголтыг хянаж баталгаажуулсан байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгосон 54 иргэдийн тэтгэврийн бүрдэлтийг хянаж дээд шатны байгууллагад хүргэж баталгаажуулж тогтоолгосон. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжид улсын төсвөөс 2,160,519,500сая төгрөгийн санхүүжилт авч 2023 онд нийт 2,052,635,937сая төгрөгийн тэтгэвэр авагчдад тэтгэврийг хугацаанд нь тавьж олгосон. Нийт 329 хувийн хэрэг цахимжуулсан Үүнээс: ӨН-278 ТА-17 ТД-34 2022.12.15-ний өдрөөс 2023.03.01-ний өдөр хүртэл 100%-ийн гүйцэтгэлээр хийж гүйцэтгэсэн. <b>Үр дүнтэй 100 хувь</b>

1	2	3	4	5	6	7	8	9	10
15	1.6. Соёлтой иргэн - Нийгмийг түүчээлнэ	Соёлын төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	Хөгжмийн төрөл, тоо	0	100	20.0	Орон нутгийн хөгжлийн сан	Соёлын төв	Соёлын төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлыг “Эгшиглэн Манлай” ХХК-тай шууд гэрээ байгуулан тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авч ашиглаж байна. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
16		Түүх соёлын дурсгалт газар, соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэх, сурталчлах, дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	0	70			Соёлын төв	Түүх дурсгалын газар сумын хэмжээнд 10 газар аймгийн хамгаалалтад 4 газар байдаг ба шинээр сумын хамгаалалтад 10 газар бүртгэж авахаар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэрэлцүүлэх зохих арга хэмжээг авч ажиллаж байна. <b>Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь</b>
17		Төрийн албан хаагч, иргэдийн үндэсний бичгийн чадварыг сайжруулах, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангах	Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварын түвшин	дунд	ахисан			Ерөнхий боловсрол ын сургууль	Сумын хэмжээнд “Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх” чиглэлээр төрийн 6 байгууллагуудын дунд “Хос бичигтэн” уралдааны удирдамж гарган зохион байгуулж ажиллалаа. Төрийн албан хаагчдын дунд 2 үе шаттай үндэсний бичгийн олимпиад зохион байгуулж, нийт 13 албан хаагч оролцсон. Үндэсний хөтөлбөр-3 хүрээнд төрийн албан хаагчдын дунд “Нэрийн хуудас”-аа үндэсний бичгээр бичих уралдаан зарлаж нийт 5 байгууллагын 85 төрийн албан хаагч нэрийн хуудастай болсон. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдад 14 хоногийн сургалтыг нэг удаа зохион байгуулж нийт 42 хүн

1	2	3	4	5	6	7	8	9	10
									хамрагдлаа. Төрийн албан хаагчдын дунд 2 үе шаттай үндэсний бичгийн олимпиадыг монгол хэлний багш нартай хамтран зохион байгууллаа. Нийт 13 албан хаагч оролцож 1-р байр Бага боловсролын багш Б.Гандолгор 2-р байр Татварын улсын байцаагч Г.Мандах, Бага боловсролын багш Х.Пүрэвмаа нар 3-р байр Математикийн баг Ж.Пагма нар тус тус эзэллээ. Сурагчдын амралтын хугацаанд давхардсан тоогоор 45 багш ажилчдад компьютерт үндэсний бичгээр бичих программ суулгаж дадлага сургуулилалтыг хийлээ. Ажилчдын баярыг угтсан “Хос сайхан бичигтэн” шалгаруулах уралдаан зарлан эхний 3 байрыг шалгаруулж шагналаа. Өргөмжлөл, дурсамжаа тогтмол үндэсний бичгээрээ бичиж хэвшсэн. Сургуулийн 42 албан хаагчид “Хүмүүн бичиг” сонин 100% захиалан захиалга өгсөн. <b>Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь</b>
18	1.7.Хонгорын иргэн - Хонгорын баялаг	Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх	Угийн бичиг хөтлөлтийн хувь	0	0			Соёлын төв	<b>ХИЙГДЭЭГҮЙ Үр дүнгүй 0 хувь</b>
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>									
19	2.1. Санхүү, эдийн засгийн	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд татвар	Төлбөрийн баримт олголтын хувь	0	100			Татварын улсын байцаагч	НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлэхийг зорин хэрэгжилтэнд хяналт тавин



1	2	3	4	5	6	7	8	9	10
	хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна	төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 60-аас дээш хувьд хүргэх							ажиллаж байна. Суманд үйл ажиллагаа явуулдаг 31 татвар төлөгч төлбөрийн баримтын системд бүрэн холбогдсон. Татвар төөгчдийн ибаримт олгож байгаа эсэхийг татвар төлөгч бүрээр ТУНС-ээс 10 хоног тутам хянаж хэдэн төгрөгийн баримт шивсэн, үнийн дүнд хяналт тавин татвар төлөгч бүртэй холбогдон баримтаа тогтмол олгож байхыг шаардан ажилладаг. Төрийн байгууллагуудтай гэрээгээр хамтран ажилладаг татвар төлөгчид төлбөрийн баримт бүрэн ашиглаж хэвшсэн. Энэ онд 2 татвар төлөгч НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн. Иргэдэд татвар төлөгчдийн ажлын байранд байрлуулсан QR кодыг хэрхэн ашиглах талаар, цахим төлбөрийн баримтаа авч байх талаарх мэдээллийг олон нийтийн цахим сүлжээ ашиглан сурталчлан ажилласан. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
20	2.3.Эрүүл хөрс - Эрүүл хүнс	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж худаг гаргах, засварлах	Шинээр гаргах худгийн тоо	0	100	14.0	Орон нутгийн хөгжлийн сан	Хөдөө аж ахуйн тасаг	Бэлчээр худгийн усан хангамжийг нэмэгдүүлэх /1-р баг/ 7000000 төгрөг Бэлчээр худгийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажил /2-р баг/ 14000000 төгрөгөөр Гео дата процессинг ХХК-тай шууд гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэн Зараа 1-р багийн нутаг Цагаан товгорт, 2-р багийн нутаг Шивээ зээрэн, аман ихэр гэсэн газруудад уст цэгийн геофизикийн хайгуул хийгдэж тогтоосон. <b>Үр дүнтэй 100%</b>

1	2	3	4	5	6	7	8	9	10
21		Сумын төвийн хүн амын ундны усыг цэвэршүүлэн эрдэсжүүлэх тоног төхөөрөмжөөр тохижуулж ухаалаг худаг болгох		0	100		Уул уурхайн компанийн хөрөнгө оруулалт	Засаг даргын Тамгын газар	“Баянхөндий” төслийн хүрээнд Ус хангамжийн систем шинэчлэгдэн 9 сард ашиглалтад орсон бөгөөд 1 тэрбум орчим төгрөгөөр хөрсний хөлдөлтийн гүнээс доош 3м дулаалж суурилуулсан 700 орчим метр шугам хоолой, ISO 9001 олон улсын стандартын шаардлага хангасан 3 түвшний шүүлтүүр, ус зөөлрүүлэгч төхөөрөмж, хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэгч бүхий ундны ус цэнгэгжүүлэх байгууламж, 8м3 танктай ухаалаг картын систем бүхий ус түгээх худгийг бүтээн байгуулсан. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
22		Мал эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн ДУК машин авах		0	100	70.0	Орон нутгийн хөгжлийн сан	Мал эмнэлгийн тасаг	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд мал эмнэлгийн халдваргүйтгэлийн Дук автомашиныг эрэмбэлүүлэн 2023 оны 6 дугаар сард Тамгын газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилогдсон. Үүнд: Ажлын хэсгийн гишүүд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Д.Хаянхярваа, Д.Дашжамц, Санхүү албаны дарга Х.Дагважав, нягтлан бодогч Х.Доржсамбуу, жолооч Ж.Шархүү, Мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн хүлээн авсан. Дук автомашиныг хүлээн авсан тухай тайлан бичиж Санхүүгийн албанд хүлээлгэн өгсөн. Дук машины бичиг баримт болон номерыг аймгийн Орон нутгийн өмчийн газар, авто

1	2	3	4	5	6	7	8	9	10
									тээврийн төвөөс бүрдүүлэн авсан. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
<b>ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>									
22	3.1. Эх байгаль - Ногоон байгууламж	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	Тарьсан модны тоо	0	100		Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарт	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд: Мод тарих ажлыг эрчимжүүлэх тухай сумын Засаг даргын захирамжийг төлөвлөн гаргуулж, хэрэгжүүлж ажиллалаа. Бүх нийтээр мод тарих ажлыг хавар, намрын байдлаар 2 удаа зохион байгуулж, нийт 168 иргэн хамрагдан ажиллаж 3800 мод таригдсан. “Сэкер ресорсус” ХХК 1000 суулгац, ерөнхийлөгчийн туслах Даваадалай 850 суулгац өгч мод тарих сонирхолтой иргэдэд тарааж өгөх, модны талбайд нөхөн тарилт хийх зэргээр ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан. “Эрдэнэ Монгол” ХХК энэ онд 62000 ширхэг мод үрээр үржүүлсэн байна. Байгууллагын хүрээнд нийт 65 мод тарьж ургуулж байгаагаас ургахгүй байсан хөрс муудсан ургалт зогссон 12 модыг хөрсийг сийрэгжүүлэн дахин шинээр суулгаад байна. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
23		Сумын хэмжээнд амьтны нэгдсэн суурь судалгаа хийж, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах		0	100		Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал	Байгаль хамгаалагч нарт	Сумын хэмжээнд амьтны нэгдсэн суурь судалгааг “Саруул од турс” ХХК хийж, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулагдан, сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нараар баталгаажсан.

1	2	3	4	5	6	7	8	9	10
									<b>Үр дүнтэй 100 хувь</b>
24		Биотехникийн арга хэмжээ авах /амьтдын байршил бүхий газруудад өвс, тэжээл байршуулах/	Давтамжийн тоо	0	100	5.4	Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал	Байгаль хамгаалагч нар	Ан агнуурын бүс нутагт өвс, хужир мараа тавих ажлыг 8 цэгт 3 удаагийн биотехникийн арга хэмжээг авч 5400000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
25		Усны тоо бүртгэлийг зохион байгуулах	Тоо бүртгэлд хамрагдах худгийн тоо	0	100		Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал		Уст цэгийн тоо тооллого 4 жил тутамд зохион байгуулагддаг бөгөөд 2023 онд АӨГСГЗ-тай хамтран булгийн тооллого хийж ажилласан. Сумын хэмжээнд нийт 50 булаг тоологдсон. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
26		Усны нөөцийн хомстол бохирдлоос хамгаалах, усны зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг өргөн зохион байгуулах	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	0	90		Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Дэлхийн усны тэмдэглэлт өдрийн хүрээнд сургуулийн сурагчдад усны хэрэглээний талаар сургалтыг зохион байгуулж 320 сурагч хамрагдсан. "Сэкер ресорсус Монголиа" ХХК-тай хамтран ус чандмань эрдэнэ сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж, 3 анги бүлгийг шалгаруулан шагнаж урамшуулсан. <b>Тодорхой үр дүнд хүрсэн 90 хувь</b>
<b>ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>									
27	4.1. Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал	Аймаг сум хоорондын авто зам засвар	Гүйцэтгэлийн хувь	0	0		Замын сангийн хөрөнгө	Засаг даргын Тамгын газар	Аймгийн хөрөнгө оруулалтын сангаас 20 сая төгрөгөөр шийднэ гэсэн боловч ажил хийгдээгүй. <b>Үр дүнгүй 0 хувь</b>
28		04-ийн шугамын өргөтгөл хийж 160кВа-ийн дэд станц барих	Гүйцэтгэлийн хувь	0	100	144.0	Орон нутгийн хөгжлийн сан	Засаг даргын Тамгын газар	Цахилгааны 04кВ-ын шугамын өргөтгөл хийх 250кВа-ын дэд станц барих ажлын тендерийг цахимаар зарлаж гүйцэтгэгчээр "Гарьд системс" ХХК шалгарч 210317268 төгрөгийн гэрээ


1	2	3	4	5	6	7	8	9	10
									байгуулан ажлыг хугацаандаа шаардлагад нийцүүлэн бүрэн дуусгаж хүлээлгэн өглөө. Өргөтгөл хийснээр өндөрлөг хорооллын айл өрхийн тогны хүртээмж эрс сайжирсан. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
29		Төрийн байгууллагуудыг цэвэр усны нэгдсэн системд холбох	Гүйцэтгэлийн хувь	0	100	1 тэр бум	Уул уурхайн компанийн хөрөнгө оруулалт	Засаг даргын Тамгын газар	“Баянхөндий” төслийн ус хангамжийн системийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн гүний худгийн барилга, цэвэр, бохир усны шугам хоолой, септик танк бүхий цэвэрлэх байгууламжийг барьж стандартын шаардлага хангасан эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөнүүдийг шинээр байгуулж ус хангамж, ариутгах татуургын системийн бүрэн шинэчлэл хийсэн. <b>Үр дүнд 100 хувь</b>
30		Хуучин хогийн цэгийг дарж булшлан шинэ хогийн цэг байгуулах	Гүйцэтгэлийн хувь	0	100		Уул уурхайн компанийн хөрөнгө оруулалт	Засаг даргын Тамгын газар	Энэ онд хогийн цэгийг дарж булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил хийгдсэн бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэн “Талын нөмөр” ХХК гэрээгээр гүйцэтгэсэн. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
<b>ТАВ.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ</b>									
31	5.1. Аюулгүй нийгэм, амар тайван орчин	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн өргөтгөл хийх	Гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийн хувь	0	100	157.8	Орон нутгийн хөгжлийн сан	Засаг даргын Тамгын газар	Гудамж талбайн гэрэлтүүлгийн өргөтгөл хийх ажлын тендерийг цахимаар зарлаж, гүйцэтгэгчээр “Ган утас мөнх” ХХК шалгарч 132,283,202.0 төгрөгөөр 6 ширхэг цамхаган гэрэл хийж гүйцэтгэсэн. Гэрлийг тог цахилгаанд холбох

1	2	3	4	5	6	7	8	9	10
									ажил хүлээгдэж байна. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
32		Гамшгаас хамгаалах "Иж бүрэн" команд штабын сургууль зохион байгуулах	Оролцооны хувь	80	90	5.0	Байгууллагын төсөв	Сумын Онцгой комисс	Гамшгаас хамгаалах "Иж бүрэн" дадлага, сургуульд сумын Онцгой комисс, Мэргэжлийн ангийн нийт 100 гаруй бие бүрэлдэхүүн бэлэн байдлыг ханган оролцож "Яаралтай цуглар" дохиогоор бүрэн жагсаж хүн нэг бүрийн үүргэвчний үзлэг, объектын гал түймэр унтраах, аврах ажиллагааг зохион байгуулах, багаж хэрэгслийг ажиллуулах, газар хөдлөлт, мал, амьтны гоц халдварт өвчний голомтод хэрхэн ажиллах талаар 3 өдрийн дадлага, сургуулилтад амжилттай хамрагдаж "Хангалттай" буюу 90%-тай үнэлэгдэв. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
33	5.2. Батлан хамгаалах салбар	Цэргийн албанд залуусыг хамруулах дүйцүүлэх хамрагдах сургалтад	Сургалтад хамрагдсан хүний тоо	0	100			Засаг даргын Тамгын газрын дарга	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа Э.Данаажав нь дуудсан хугацаанд бэлэн байж Эрдэнэцогт сумын 100 жилийн ойд зориулсан бүтээн байгуулалтын ажилд оролцсон. Мөн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа О.Чойжилсүрэн, Т.Тодбилэг нар нь "Тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт"-д хамрагдаж сум орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд идэвхтэй оролцдог болно. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
34		Ерөнхий боловсролын						Засаг	Шинэжинст, Баян-Өндөр сумдын

1	2	3	4	5	6	7	8	9	10
		ахлах ангийн сурагчдын дунд эх оронч үзэл, хүмүүжил олгох урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах	Хэрэгжилт ийн хувь	0	100			даргын Тамгын газар	ИТХ, ЗДТГ-ын санаачилгаар сумдын ЕБС-ийн 9-р ангийн 36 сурагч Хилийн цэргийн 0166 дугаар ангийн "Сэгс Цагаан Богд", "Хатан суудал", "Зам билгэх"-ийн заставуудаар айлчилж МУ-ын хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаатай танилцан сүлдэт баганад хүндэтгэл үзүүлэн орон нутгийнхаа байгалийн сайханд 750км зам туулан экскурс аялал зохион байгууллаа. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
<b>ЗУРГАА. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>									
35	6.1. Ухаалаг засаглал	Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулж, цахим мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт хийх	Үйлчлүүлсэн иргэдийн тоо, цахим системийн хөгжүүлэлт ийн хувь	0	100			Төрийн үйлчилгээний оператор	Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд shinejinst.gov.mn веб сайт, Шинэжинст ЗДТГ фэйж(410like, 542followers), Shinejinst shinejinst (1000friend) фэйсбүүк хаяг нээн тус бүр 3 сошиал медиагаар иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Жилийн хугацаанд онцлох үйл явдлын 18 зурган мэдээ, видео бичлэг 2, постер 7, зарын чанартай 20 мэдээг нийтэлж ажилласан. Мөн жилийн эцсийн байдлаар нийт 10 төрлийн үйлчилгээ, 210 лавлагааг операторын эрхээр, давхардсан тоогоор 125 хүнд имонголиа нээж, нууц үг солих, бүртгэлтэй утасны дугаар солих үйлчилгээ үзүүлж, ажилласан байна. <b>Үр дүнтэй 100 хувь</b>
36		Төрийн бүтээмжийг сайжруулах, албан	Хэрэгжилт ийн хувь	0	100	132.0	Хөгжлийн	Төрийн	Төрийн албан хаагчдын тогтвортой ажиллуулах бодлогыг

1	2	3	4	5	6	7	8	9	10
		хаагчдын тогтвортой ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх					төлөвлөг өө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	захиргааны удирдлагын хэлтэс	хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай байгаа эмч, сувиагч, бага ангийн багшийн тогтвор суурьшилтай байх нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж сумын ИТХ-аар батлуулсан. <b>Тодорхой үр дүнд хүрсэн 90 хувь</b>
37		Архив, бичиг хэргийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, мэргэшүүлэх, удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын архив албан хэрэг хөтлөлтийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх	Шинээр элссэн, мэргэшсэн ажилтны тоо					Засаг даргын Тамгын газар	2023 оны 1 сард баянхонгор аймагт "Төрийн архив албан хэрэг хөтлөлтийн шинэчлэлт, өөрчлөлт" сэдэвт сургалтад 6 байгууллагын Архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг оролцуулсан. Цэцэрлэгт архив, албан хэрэг хөтлөлтийн чадамжийн гэрчилгээ олгох сургалтад хамрагдсан үнэмлэхтэй боловсон хүчинг сонгон шалгаруулалтаар оруулан ажилд авсан. <b>Үр дүнтэй 100 хувь</b>

ХЯНАСАН  
ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
ХУУЛЬ ЭРХ, ЗҮЙН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Т.БАТЧИМЭГ



ШИНЭЖИНСТ СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
2023 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 оны 12 дугаар сарын 15

Залаа

СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО		
<b>Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо:37</b>		
Үүнээс:	<b>Үр дүнтэй: 100%</b>	28
	<b>Тодорхой үр дүнд хүрсэн: 90-70%</b>	90%-3, 70%-2
	<b>Эрчимжүүлэх шаардлагатай: 50-30%</b>	50%-1, 30%-1
	<b>Үр дүнгүй: 0</b>	2
Хөгжлийн төлөвлөгөөний 2023 оны биелэлт <b>89 хувь</b> байна.		

ХЯНАСАН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА  Л.БАТХУЯГ

ТОВЧОО ГАРГАСАН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Г.БАТЧИМЭГ